

“УЛААНХҮҮ” УБ., 2021 ХЭМЭЭХ НОМЫН ТУХАЙД

Дашнямын Золбоо

*ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, доктор (Ph.D), дэд профессор
zolbood@mas.ac.mn*



Өнгөрөгч 2021 онд нэгэн “онцлог” бүтээл мэндэлсэн нь “Улаанхүү” хэмээх ном юм. Уг номыг “БНХАУ-ын төрийн удирдагчид цуврал”-ыг бүтээж буй хятад судлаач, докторант Хорлоогийн Баатархүү тус цувралынхаа II боть болгон хэвлүүлсэн байна. Өмнө нь тэрбээр “Ард түмний ерөнхий сайд Жоу Энълай” УБ., 2018 хэмээх бүтээлийг нийтэд хүргээд байсан билээ.

Уг бүтээл агуулгийн хувьд өнөөгийн Өвөр Монголын Өөртөө

Засах Орныг үндэслэгчдийн нэг, нэрт хувьсгалч, коммунист зүтгэлтэн, БНХАУ-ын нам, төрийн удирдагч, Өвөр Монголын төдийгүй БНХАУ-ын түүхэнд ул мөрөө гүнзгий үлдээсэн Улаанхүүгийн намтар, үйл хэрэгтэй холбогдох зарим асуудлыг тоймлон өгүүлжээ.

Хүн төрөлхтний XX зууны түүхэнд өөрийн байр суурийг баттай эзэлдэг Мао Зэдун нарын Хятадын улс төрийн зүтгэлтнүүдтэй нэгэн үед амьдарч, хамтран ажиллаж байсан Өвөр Монголчуудын дундаас тодрон, өөрийн түүхэн үүргийг гүйцэтгэсэн хүмүүсийн нэг нь Хятадын түүхэнд Улаанхүү хэмээн алдаршин үлдсэн орос Ласевтч, монгол Оюундалай, хятад Юн Ши-Үй зэрэг нэр зүүж явсан Түмэдийн зүүн хошууны Чин Чүн (1906-1988) юм.

Энэхүү бүтээл нь Эрдэмд шамдсан хүүхэд нас, Алсын аяны дөрөө, Хувьсгалт тэмцэлд хорин жил, ӨМӨЗО байгуулагдсан нь, Өвөр Монголын эдийн засгийн их бүтээн байгуулалт, Төрийн хүн, Улаанхүү ба БНМАУ,



<https://creativecommons.org/licenses/by/4.0/>

<https://orcid.org/0000-0001-7880-8526>

Тал нутгийн хувьсгалын түүчээ хэмээх дор бүрнээ 2-4 хэсгээс бүрдэх үндсэн найман бүлэгтэй, 300 гаруй гэрэл зургийг хавсаргасан, нийт 200 нүүр өнгөт хэвлэл бүхий ном юм. Эдгээрээс эхний зургаан бүлэг нь текст өгүүлэмжээр бичигдсэн бол сүүлийн хоёр бүлэг нь холбогдох баримт бичиг, түүхэн гэрэл зургуудын тайлбараас бүрджээ.

Тэрээр нэг талаар Мао Зэдун тэргүүтэй Хятадын коммунист хувьсгалчид буюу БНХАУ-ын анхдугаар үеийн удирдагчидтай нэгэн цаг үед амьдарч, хамтран ажиллахдаа коммунист хувьсгалыг ялуулах их үйл хэрэгт идэвхийлэн зүтгэж, улмаар тус улсын нам, төрийн өндөр албыг олон жилээр үүрэглэж байсан монгол хүнийхээ хувьд, нөгөө талаар түүхэн ээдрээ будлиантай зам мөрийг туулахдаа чөлөөт түүх судлалд эрс тэс хандлагаар тэмдэглэгддэг хувьсгалчийнхаа хувьд ч монголчууд Та биднээс тухайн хүний талаар заавал тодорхой түвшний ойлголттой байхыг шаарддаг өвөрмөц намтар цадигтай, үйл хэргийн төвөгтэй зам мөртэй түүхэн бие хүн байсан билээ.

Иймийн тул уг хүний талаарх тусгай бүтээлийг эрхлэн гаргана гэдэг нэг талаар эр зориг, нөгөө талаар нягт хянамгай ажиллахыг шаардсан амаргүй ажил гэдэг нь тодорхой. Х.Баатархүү судлаач энэ бүхнээс үл шантран багагүй цаг зав зарцуулан хичээн зүтгэж байж энэхүү бүтээлийг баринтагласан нь ийнхүү түмний гарт хүрч, олны оюуныг мялааж байгаа нь сайшаалтай.

Бид эхэнд энэхүү бүтээлийг “онцлог” хэмээн тодорхойсон учраа

олон талаар тайлбарлаж болох ба Үүнд,

Нэг. ХХ зууны Өвөр Монголын улс төр, нийгмийн зүтгэлтнүүдийн намтар судлалаар манай улсад судалгааны бүтээлүүд нэлээд гарсан ба тийм бүтээлүүдийн тоонд Дэ ван, Бавуужав, Хайсан гүн зэрэг үндэсний үзэлт түүхэн хүмүүсийн талаарх зохиолуудыг дурдаж болно. Харин Өвөр Монголын коммунист хувьсгалчдын талаарх бүтээл өнөөг хүртэл манай улсад гарч байгаагүй ба энэхүү хоосон орон зайг нөхвөрлөн гарч ирснээрээ уг бүтээл анхдагчийн байр суурийг эзлэх онцлогтой болжээ.

Хоёр. Энэхүү бүтээл гарснаар Улаанхүүгийн намтар монгол хэлээр хоёр дахь удаагаа хэвлэгдэж байгаа тохиолдол болж байна. 2007 онд БНХАУ-ын Үндэстний хэвлэлийн хорооноос монгол бичгээр “Улаанхүүгийн намтар”-ыг хэвлэн тараасан бол энэ удаад крилл монгол үсгээр Монгол Улсын уншигчдад зориулан гаргасан онцлогтой болжээ.

Гурав. Энэхүү бүтээл нь Улаанхүүгийн намтарт холбогдох зарим асуудлуудыг хөндсөнөөрөө бүрэн намтар биш юм. Харин БНХАУ-ын нам, төрийн зүтгэлтнүүдийн албан ёсоор тогтоосон түүх бичлэгийг баримталсан ба бие хүний ээдрээ будлиантай хэрэг явдлууд тухайлбал, хэлмэгдсэн он жилүүд хийгээд хувь хүний хувийн амьдралыг дэлгэрэнгүй оруулахаас зайлсхийсэн зэрэг нь бүхэлдээ Улаанхүүгийн намтар, зүтгэлийг БНХАУ-д хэрхэн авч үздэгтэй танилцах боломжийг уншигчдад олгосноороо бас нэгэн онцлогтой байна.

Дөрөв. Хэдийгээр энэ бүтээл

БНХАУ-д хэвлэгдсэн “Улаанхүүгийн намтар” (乌兰夫传), “Улаанхүүгийн сонгомол зохиолууд” (乌兰夫文选) гэх албаны эх сурвалжид тулгуурласан боловч дагалдах түүхэн баримтуудыг нэлээд хэмжээгээр хамтатгаснаар онцлоготой байна. Тухайлбал, Улаанхүү ба түүний үйл хэргийг залгамжлан БНХАУ-ын нам, төрийн өндөр албанд ажилласан хүү Бөхөө, ач охин Бү Сяолинь нарын Монгол Улсад хийсэн албан айлчлалын гэрэл зургууд, түүнчлэн Монгол Улсын Үндэсний төв архив, Гадаад харилцааны төв архивын сан хөмрөг дэх баримт бичгүүд, сонин хэвлэлд гарсан нийтлэл, ярилцлага, мэдээллийг мөн гэрэл зургаар багтаасан нь сонирхолтой болжээ.

Тав. Хүний нэрийн болон газар усны нэрийн заагуур үйлдэх, ашигласан баримтуудыг жагсаалт үйлдэх, эшилсэн сурвалжуудыг дурьдах зэргээс татгалзсан нь уг номыг эрдэм шинжилгээний бүтээл биш гэдгийг илтгэхийн зэрэгцээ нийтэд хялбаршуулсан байдлаар Улаанхүүгийн намтарыг анхдагч түвшинд хүргэх гэсэн онцлогийг харуулж байна. Ийм учраас судлаач Х.Баатархүү өөрийн оролцоогоо энэхүү бүтээлд “эмхэтгэн, орчуулсан” хэмээн тодотгон өгсөн байна.

Мэргэн уншигчид таалан болгоох ажаамуй.